



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ**

2022 оны 09 сарын 29 өдөр

Дугаар 404

Улаанбаатар хот

**Я.Нямжаргалтай байгуулсан  
Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээг  
дуусгавар болгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 9 дэх хэсэг, 18 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 78.1.9 дэх хэсэг 80.1.1 дэх хэсэг 82.1.1 дэх заалт, Засгийн газрын 2022 оны 08 дугаар сарын 24-ний өдрийн 318 дугаар тогтоол, Я.Нямжаргалтай байгуулсан Онцгой нөхцөл бүхий 2022/15/к дугаартай хөдөлмөрийн гэрээг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Эрчим хүчний хөгжлийн төв” төрийн өмчит үйлдвэрийн газар, “Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв” төрийн өмчит үйлдвэрийн газруудыг нэгтгэн өөрчлөн зохион байгуулж, “Эрчим хүчний үндэсний төв” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани байгуулсантай холбогдуулан “Эрчим хүчний хөгжлийн төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал Я.Нямжаргалтай байгуулсан Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээг 2022 оны 09 дүгээр сарын 29-ний өдрөөр дуусгавар болгосугай.

2. “Эрчим хүчний хөгжлийн төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал Я.Нямжаргалтай байгуулсан онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээг дуусгавар болгосонтой холбогдуулан 6 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний тэтгэмж олгохыг татан буулгах ажлын хэсэгт даалгасугай.

3. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН  
ДАРГА

Ц.БАЯР-ЭРДЭНЭ